

**МОНГОЛ УЛСЫН ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН НИЙТИЙН  
ХЭВ ЖУРАМ ХАМГААЛАХ АЛБАНЫ ТҮҮХЭН ХӨГЖИЛТ  
РАЗВИТИЕ ИСТОРИЯ СЛУЖБА ОХРАНА ОБЩЕСТВЕННОГО  
ПОРЯДКОВ ОРГАНОВ ПОЛИЦИИ МОНГОЛИИ**

*Цагдаагийн эрх зүйн тэнхмийн  
ахлах багш, цагдаагийн  
хурандаа А.Баасанцэрэн  
baaskaa0522@gmail.com*

*Старший преподаватель,  
кафедры Полицейского права,  
Полицейского института  
Университета внутренних дел  
Монголии, полковник полиции  
Баасанцэрэн Авирмэд*

**Товч утга:** Монгол улсын Цагдаагийн байгууллагын хэв журам хамгаалах албаны үүсэл хөгжил, Богд хаант монгол улсын цагдаагийн байгууллагын хэв журмын албаны хөгжил, ардын засгийн цагдаагийн хэв журам сахиулах сэргийлэх цэрэг, үечлэл, үүсэж хөгжсөн нөхцөл байдал, шалтгаан, нийгмийн захиалга, эрдэм судлаачдын дүгнэлт судалгаа, өнөөгийн нөхцөл байдал, эрх зүйн зохицуулалт

**Аннотация:** Развитие Охрана общественного порядков Органов Полиций Монголии, Эпоха Богд хаан, Народное власти и современное период развитие научно-практические социальная характер, исследовательское оценка правовое регулированное.

**Түлхүүл үг:** Хэв журам хамгаалах, арван тавны цагдаа, сэргийлэх цэрэг, Цагдан сэргийлэх, сэргийлэн хамгаалах,

**Ключевые слова:** Охрана общественного порядок, Органов Милиции, пятнадцать разделенное полиции, профилактических солдат, охрано и предупреждение.

**Арван тавны цагдаа бий болсон нь: 1865-1921 он**

Монгол улсад орчин цагийн цагдаагийн байгууллага нь 1921 оны 7-р сарын 11-ний өдрөөс үүсэж хөгжсөн түүхтэй гэж үзэж эдүүгээ 100 жилийн ой энэ онд тохиож байгаа хэдийч Монгол улсад эрт дээр үеээс хүрээ хот сууринд хэв журам сахиулах үүрэгтэй төр цэргийн нэгж ажиллаж байсан.

Эзэн Чингис хаан 1206 онд их монгол улсыг байгуулж дараа их хааны хүрээнд аливаа бусармаг үйлдэл, хулгай, дээрэм галын аюулгүй байдлаас сэргийлэх зорилгоор эргүүл гаргаж байсан түүхтэй байна, үүний нэг жишээ бол Их эзэн Чингис хааны хишигтэн, хэвтүүл зэрэг цэргүүдээр харуул манаа гаргаж байсан ба хэрэг явдал гарсан тохиолдолд төрийн их заргач аливаа хэрэг маргааныг шийдвэрлэж ирсэн түүхэн уламжлалтай байна.

Анх цагдаа гэдэг нэр томъёо Монгол улс манж чин гүрний эрхшээлд байх үед буюу 1865 оны 12-р сарын 29 өдөр Богдын зарлигаар Түшээт хан, Сэцэн хан аймгуудын чуулган дарга, Богдын шавь Эрдэнэ шанзудовын газраас тусгай түшмэлүүд томилж гаргаж их хүрээнд хэв журам сахиулах, хулгай дээрэм, галын аюулаас сэргийлэх арга хэмжээ авахдаа Их хүрээний

нутаг дэвсгэрийг төвөөс нь тал бүр тийш гурав хувааж, нэр бүхий хоёр аймаг, Богдын шавьд хариуцуулах болсон байна.

Ийнхүү гурав хуваасан газраа тус бүрд нь 361 алдыг нэгэн газар (576 метр газар) болгож хэмжээд нэгэн газар тутамд нийгмэд тэмдэг тавьсанаар арван таван газар болгон хуваагаад тэр газар бүрийн эцэст тусгай пайз хатгаж, овоо тэмдэг үйлдэж босгохоор шийдвэрлэжээ.

Ийнхүү арван таван газрыг Түшээт хан, Сэцэн хан, Их шавьд анх хариуцуулж (хожим нь Сайнноён Засагт хан аймаг нэмэгдэсэн), орон тоо өрхийн цагдааг аймаг шавь тус тусаасаа томилон ажиллуулах журам тогтоосноос сүүлдээ “Арван тавны цагдаа” гэж нэрлэх болжээ. 1890-ээд оны эцэст Их хүрээнд орон тооны цагдаа 10 тэдгээрийн уналгын морь 40, эдгээр цагдаа нарын уналга нь халх дөрвөн аймгаас хувиарлан хангадаг<sup>1</sup> гэж тэмдэглэсэн байна.

Энэ үед гол үүрэг нь Нийслэл хүрээнд хэв журам сахиулах, хулгай дээрэм өдүүлэгчийг олж илэрүүлэх, хэрмэл цагаачин хүмүүсийг орон нутагт нь буцаах, галын аюулаас хамгаалах, гэмт хэргээс сэргийлэх зорилгоор хүрээний дотор талаар явган эргүүл, гадна талаар морьт эргүүлийн үүрэг гүйцэтгэж ирсэн нь өнөөгийн Цагдаагийн байгууллагын эргүүл харуулын үйл ажиллагааны эхлэл байсан байна.

XX зууны эхэн үеээс Манж чин улсын хүч суларч, Монголд явуулж буй бодлого чангарсаны улмаас Монголын нийгмийн бүх шатанд манжаас салах тусгаар улс болох эрмэлжлэл өрнөж эхэлсэн энэ үед 1911 оны сүүлээр үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн өрнөж, Монголын эхэс дээдэс ван гүн, лам ноёд аль болох манжаас тусгаарлах, тусгаар тогтнолоо сэргээхийн төлөө нэгдэж тэмцэсний үр дүнд 1911 оны 12-р сарын 29-ны өдөр 8-р Богд Жавзандамба хутагтыг Монгол улсын хаанаар өргөмжилж Монгол улс тусгаар тогтносон улс болсоноо зарлаж байна.

Богд хаант Монгол улсын үед цагдаагийн байгууллагын талаар 1916 онд Нийслэл хүрээний тойрон газруудыг цагдан сэргийлүүлэх дүрэм батлан гаргаж, энэ дүрэм нь 27 зүйлтэй байсан нь тухайн үед гол эрх зүйн зохицуулалт нь болж байсан байна. Уг дүрэмд “Нийслэл хүрээнд суугаа аливаа олон ард нь Улсын засгийн цааз дүрэм хэмжээ дагуулан гэм аюулгүй амар жимэр суулгахын учир”<sup>2</sup> Нийслэл хүрээнд цагдан сэргийлэх албаны газар байгуулах цэргийн яаманд харьяалуулах, ажилтан дүрэмт хувцас, зэвсэг хэрэглэх, орон тоог заасан байдаг нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, олон нийтийн газруудад хэв журам сахиулах тусгай байгууллага байх үндэстэй байна.

1911 онд Монгол Улс тусгаар тогтнолоо сэргээн тунхагласны дараа Манж Чин улсын цагдаагийн байгууллагад ажиллаж байсан монгол цагдаа нарыг Цэргийн яамны харьяа морьт цагдаа цэрэг, явган цагдаа цэрэг болгон өөрчлөн зохион байгуулснаар Монгол улсын төрийн цагдаа анх бий болжээ. Ийнхүү 1911 оны 12 сарын 12-нд Манж Чин улсын үеийн монголын цагдаа болох Хүрээний тойрон 15 газрыг цагдах түшмэл цэргүүдийг хэвээр үлдээж, шинэ төрдөө хүчин зүтгүүлэх болсон байна.

Эл шийдвэрт Богд хаан уулын цагдаагийн тухай дурдаагүй боловч уг цагдааг хэвээр үлдээж, хожим Ардын засгийн эхэн үе хүртэл ажиллуулсан байна. Энэ үед хэв журам сахиулах Арван тавны цагдаа нь Нийслэл хүрээнд хэв журам сахиулах, хулгай дээрэм, галын аюулаас

<sup>1</sup> А.Думбарай. Монгол төрийн цагдаагийн уламжлал түүхэн хөгжилт 1998 он.

<sup>2</sup> Ж.Долгорсүрэн. Монголын Цагдаагийн байгууллагын захиргааны үйл ажиллагааны онол практикийн үндсэн асуудал 12-р тал 1995 он.

урьдчилан сэргийлэх, Орос улсын консулын газарт харуул томилж ажиллуулсан нь Цагдаагийн эргүүл харуулын алба бий болсон гэх үндэстэй учир түүхэн цаг үед нэр төртэй гүйцэтгэж ирсэн байна.

### **Орчин үеийн Цагдаагийн байгууллагын түүхэн хөгжилт 1921-1990 он**

1920 оны цагдаагийн байгууллагын үндсэн үүрэгт хэв журам хамгаалах нь Нийслэл хүрээнд хэв журам сахиулах эргүүл хийх, гадаадын ороны консулын газрыг хамгаалах зэрэг үүрэг гүйцэтгэж байсаны нэг жишээ бол Оросын консулын харуул байсан бол, 1921 оны 7-р сарын 19-ны өдөр Жанжин Д.Сүхбаатарын санаачлагаар Нийслэл хүрээнд Сэргийлэн цэрэг нэртэйгээр байгуулагдаж орчин үеийн цагдаагийн байгууллагын эхлэл тавигдсан түүхтэй бол голлох үүрэг нь Нийслэл хүрээнд хэв журам сахиулах, хулгай дээрэмээс сэргийлэх, галын аюулаас хамгаалах үүрэгтэй байсан бол 1923 оны намар 9-р сараас Бүгд найрамдах Тува улсын консулын харуул<sup>3</sup> бий болсоноор цагдаагийн байгууллагаас Улсын онц чухал объектын харуул хамгаалалтын алба үүссэн гэж үзэх үндэстэй байна.

Улсын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 1926 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн хурлаар УЦСГ-ын дүрмийг баталжээ. Ийнхүү Улаанбаатар хот болон бүх аймгуудад цагдан сэргийлэх анги байгууллагыг байгуулахад хэв журам сахиулах үйл ажиллагаа голлох үүрэгтэй байсан бол 1934-1960 оны үед Цагдан сэргийлэх байгууллагад тусгайлсан чиг үүрэг бүхий төрөлжсөн мэргэжлийн албад, аймаг, хотод цагдан сэргийлэх анги бий болж үйл ажиллагаа нь өргөжсөн юм. Энэ үед хэв журам сахиулах үүрэгтэй сэргийлэн хамгаалах, галын аюулаас хамгаалах, хүний амь, дээрэм, хулгай, өмч ашиглах, дамын наймаа хийгчид, танхайрагчид, хууль ёс зөрчигчидтэй тэмцэх, иргэдийг паспортжуулах, гэр бүлийн байдлыг бүртгэх, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах албыг бэхжүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлж ажилласан байна.

МАХН-ын Төв Хорооны Улс төрийн товчоо Цагдан сэргийлэх байгууллагын ажлын тухай хэлэлцээд 1957 оны 07 дугаар сарын 16-ны өдөр УЦСГ-ын ажлыг сайжруулах, ажиллах нөхцөл бололцоогоор хангах талаар авах арга хэмжээний тухай 19 тоот тогтоол гаргажээ. Уг тогтоолд Цагдан сэргийлэхийн ажилтнууд нь ажилдаа ихээхэн туршлага хуримтлуулж байгааг онцлон тэмдэглэж, Цагдан сэргийлэх байгууллагын Онц сэргийлэгч, гал сөнөөгчдийн анхдугаар зөвлөгөөнийг мөн онд хийж, ажил, туршлагаараа шалгарсан хүмүүсийг Нийгмийг аюулаас хамгаалах яамны сайдын тушаалаар “Онц сэргийлэгч” тэмдгээр эхэн үед хэв журам сахиулах сэргийлэгч, “Онц гал сөнөөгч” тэмдгээр гал сөнөөч нарыг шагнадаг байсан байна, 1990-1996 онд Цагдаагийн ерөнхий газрын дарга олгодог байв. Онц сэргийлэгч тэмдгийн нэр “Цагдаагийн алдар” болж өөрчилөгдөн, Монгол Улсын Засгийн Газрын гишүүний шийдвэрээр олгох<sup>4</sup> болсон байна.

Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1985 оны 03-р сарын 29-ны 255-р зарлигийн 7-р зүйлд Цагдан сэргийлэх байгууллагын үндсэн үүрэгт гудамж талбай, цэцэрлэг, цэнгэлдэх хүрээлэн, тээврийн зам, төмөр зам болон нисэх онгоцны буудал, үзвэр үйлчилгээний болон олон нийтийн бусад газарт нийгмийн хэв журам хамгаалах явдлыг хангах<sup>5</sup> гэж заасан нь Хэв журам

<sup>3</sup> Цагдаагийн байгууллагын 100 жилд зориулсан Нийтийн хэв журам хамгаалах, Олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны түүхэн замнал. Уб.2021. 80 дахь тал.

<sup>4</sup> Цагдаа, Дотоодын цэргийн нэвтэрхий толь. Уб. 2021. 199 дэх тал.

<sup>5</sup> Монгол Улсын цагдаагийн түүхэн баримт бичгийн эмхэтгэл 1911-2021 он. Уб.2021. 343 дахь тал.

хамгаалах алба нь Цагдаагийн байгууллагын бүх цаг үед түүхэнд тэргүүлэх чиг үүрэгтэйгээ ажиллаж ирсэн байна.

### **Ардчилал шинэчлэлтийн үеийн Цагдаагийн байгууллага**

#### **Хэв журам хамгаалах алба 1990 оноос хойшхи:**

АИХ-ын Тэргүүлэгчдийн зарлиг гарсантай холбогдуулан Сайд нарын Зөвлөлийн 1990 оны 4 дүгээр сарын 19-ний өдрийн “Цагдан сэргийлэх байгууллагын зохион байгуулалтын бүтцийг шинэчлэн батлах тухай” 192 дугаар тогтоол гаргаж, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн шууд удирдлага дор, Улсын Цагдан сэргийлэх ерөнхий газрыг бие даалган зохион байгуулав. Ардчилал шинэчлэл эрх зүйт төрийг бий болгох үйл явц эрчимтэй өрнөж байсан энэ үед цагдаагийн үйл ажиллагаа, бүтэц, тогтолцоог зарлиг, тогтоолоор бус хууль тогтоомжоор зохицуулах нийгмийн хэрэгцээ аяндаа урган гарч ирсэн юм.

Энэ үед АИХ-ын Тэргүүлэгчдийн 120-р зарлиг /архидан согтуурах/, 111-р зарлиг /Танхайрах/, 191-р зарлиг /Хутга мэс зэвсгийн чанартай биедээ авч явах/ гэсэн зарлигуудаар Цагдан сэргийлэх байгууллагын хэв журам хамгаалах үйл ажиллагааны эрх зүйн гол эх сурвалж болж байсан байна, Мөн түүнчлэн төв орон нутгийн цагдан сэргийлэх байгууллагын бие даасан нэгж сэргийлэн хамгаалах алба нэгжтэй ажиллаж ирсэн /Сэргийлэн хамгаалах ахлах байцаагч/ буюу одоогоор хэв журмын ахлах байцаагч, /Сэргийлэн хамгаалах байцаагч/ буюу одоогоор Хэсгийн байцаагч гэсэн нэр томъёотойгоор хэв журам хамгаалах үүрэг гүйцэтгэж ирсэн. Монгол Улсын Их хурлаас 1993 оны 12 дугаар сарын 2-ны өдөр “Цагдаагийн байгууллагын тухай хууль”-ийг батлан гаргасанаас хойш Цагдаагийн ерөнхий газарт Хэв журмын алба, хэлтэс, Нийслэлийн цагдаагийн газар Хэв журмын хэлтэс, Орон нутгийн цагдаагийн байгууллагын газар хэлтсийн бүтэцэд Хэв журмын тасаг, хэсэг нэртэйгээр ажиллаж байсан бол, 2013, 2017 онуудад ЦЕГ-ын Нийтийн хэв журам хамгаалах, Олон нийтийн аюулгүй байдлыг хангах алба, Нийслэлийн Цагдаагийн удирдах газарт Нийтийн хэв журам хамгаалах газар, Орон нутгийн Цагдаагийн газар хэлтэст Нийтийн хэв журам хамгаалах тасаг, хэсэг тус тус шинэчлэгдсэн юм.

Өөрчлөлт шинэчлэлийн энэ цаг үед Монголын Цагдаагийн байгууллагыг цаашид хөгжүүлэх хөгжлийн хөтөлбөрөө боловсруулан, Засгийн газраа батлуулан хэрэгжүүлэн ажиллаж байна. Эцэс нь “Хуулиар тогтоосон хэв журмыг сахин хамгаалахын хувьд хөдөлмөрчин бүр өөрийгөө нэг ёсондоо ардын цагдаа гэж үздэг байх ёстой” Ю.Цэдэнбал<sup>6</sup> гэсэн үгээр төгсгөж байна.

#### **Дүгнэлт.**

1. Цагдаагийн байгууллагын Нийтийн хэв журам хамгаалах алба нь түүхэн хөгжлийн явцад Улс эх орныхоо дотоод аюулгүй байдал, нийтийн хэв журам хамгаалах, ард иргэдийн амгалан тайван ажиллах амьдрах нөхцлийг хангах голлох үүрэгтэй явж ирсэн нь түүхэн их сурвалжаас мэдэгдэж байна.

2. Монгол улсын Цагдаагийн байгууллагын түүхэн хөгжил бол Хэв журам хамгаалах албаны үүсэл хөгжил гэж ойлгох бүрэн үндэстэй байна, Иймд Цагдаагийн байгууллагын хэв журмын албаны түүх бол Цагдаагийн байгууллагын түүх гэж болно.

---

<sup>6</sup> Монгол цагдаагийн он дарааллын түүхчилсэн хураангуй 2016 он.

3. Цагдаагийн байгууллагын бусад төрөл мэргэжлийн албад түүхэн хөгжил үүсэж бий болсон тэмдэглэлт өдөртэй тухайн тэмдэглэлт өдрийг жил бүр тэмдэглэн өнгөрүүлж байгаа сайхан уламжлалтай байна, Нийтийн хэв журам хамгаалах, Олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны үүсэж хөгжсөн тэмдэглэлт өдөр одоогоор байхгүй байна.

**Санал.** Дээрхи дүгнэлтийг үндэслэн дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Цагдаагийн байгууллагын Нийтийн хэв журам хамгаалах, Олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны түүхэн хөгжил, тэмдэглэлт өдрийг бий болгох, энэ албанд ажиллаж байгаа алба хаагчдын урам зоригийг сэргээх, урамшуулах, тэмцээн уралдаан зохион байгуулах тэмдэглэж байх нь зүйтэй байна.

2. Цагдаагийн байгууллагын Нийтийн хэв журам хамгаалах, Олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны түүхэн хөгжил, тэмдэглэлт өдрийг жил бүрийн 12-р сарын сүүлийн 7 хоногийн 5 дахь өдрийг Цагдаагийн ахлагч бүрэлдэхүүний өдөр болгох /Нийтийн хэв журам хамгаалах, Олон нийтийн аюулгүй байдлыг хангах алба хаагчдын өдөр/ шаардлагатай байна.

#### **Ашигласан материал:**

1. Нийтийн хэв журам хамгаалах, Олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны түүхэн хөгжилт зурагт альбом. УБ. 2021

2. А.Думбарай. Монгол төрийн цагдаагийн уламжлал түүхэн хөгжилт. УБ. 1998.

3. Ж.Долгорсүрэн. Монголын Цагдаагийн байгууллагын захиргааны үйл ажиллагааны онол практикийн үндсэн асуудал. УБ. 1995.

4. А.Баасанцэрэн. Цагдаагийн алба хаагчын эрх зүйн баталгаа, түүн хийх шинжилгээ. УБ.2005. /хууль зүйн магистрын ажил/

5. Монгол Улсын Цагдаагийн түүхэн баримт бичгийн эмхэтгэл 1911-2021 он. УБ.2021.

6. Цагдаа, Дотоодын цэргийн нэвтэрхий толь. УБ.2021.

7. Монгол цагдаагийн он дарааллын түүхчилсэн хураангуй. УБ.2016.